Б ЭНД С АУДИТ ХХК

# АУДИТЫН ТАЙЛАН

## "ХОТЫН ТӨВ НОМЫН САН"-ИЙН

## 2012 ОНЫ 12-Р САРЫН 31-НЭЭРХ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Улаанбаатар хот

2013

НИЙСЛЭЛИЙН АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Ц.Жигжиджавын гудамж 9, "Хангарьд ордон",
Утас: 32-77-34, Факс: (976-11) 32-01-54,
E-mail: ub@audit.mn; http://www.city.audit.mn

2013.03.04 № 292

танай ______________-ны №______________-т

ХОТЫН ТӨВ НОМЫН САНГИЙН ДАРГА
Ө.ГАН-ӨЛЗИЙ ТАНАА

# АУДИТЫН ГЭРЧИЛГЭЭ

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.2, 18.5 дах заалтуудыг үндэслэн Хотын төв номын сангийн 2012 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан болон холбогдох бусад тайлан, илчлэл тодруулгад Нийслэлийн Аудитын газрын захиалгаар "Би энд Си аудит " ХХК аудит гүйцэтгэлээ.

***Үүрэг хариуцлагын талаархи мэдээлэл***

Хотын төв номын сангийн удирдлага санхүүгийн тайланг Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт / УСНББОУС/-ын дагуу хугацаанд нь үнэн зөв гаргах үүрэгтэй. Тус санхүүгийн тайлан нь УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь аудитын байгууллагын үүрэг юм.

***Санал дүгнэлтийн үндэслэл***

Бид аудитаа Нягтлан бодогчдын олон улсын холбооноос баталсан Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Үндэсний аудитын газраас гаргасан Санхүүгийн аудитын гарын авлагын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, гарын авлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй нотолгоо олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг биднээс шаарддаг. Иймд аудитаар санхүүгийн тайлан дах дүн хэмжээ болон илчлэл тодруулгыг дэмжих нотлох зүйлийг сорил түүврийн үндсэн дээр шалгаж, удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн зарчим, хийсэн чухал тооцоолол, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлдэг.

Бидний хийсэн аудит, олж авсан нотолгоо нь Хотын төв номын сангийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Монгол Улсын төсвийн байгууллагуудад мөрдүүлж байгаа Сангийн сайдын тушаалаар баталсан нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын заавар, журам нь Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын заримтай нийцэхгүй байна. Тухайлбал: Төсвийн байгууллагууд санхүүгийн

тайлангаа аккруэл сууриар бус, аккруэл-мөнгө хольсон сууриар тайлагнаж байхаар журамласан нь авлага, өглөг, хөрөнгө, тайлант үеийн орлого, зардал, үр дүнгийн үзүүлэлтүүд олон улсын стандартаас зөрүүтэй илэрхийлэгдэх магадлалтай.

Сангийн яамнаас нэгэнт бүх төсөвт байгууллагуудад дээрхи заавар журмыг мөрдүүлсэн учраас санхүүгийн тайланг түүнтэй нийцүүлэн аудит хийв.

**Хязгаарлалттай дүгнэлтийн үндэслэл**

2012 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд доорх зөрчил илэрлээ. Үүнд:

- 2012 оны батлагдсан төсвийг 11,776.1 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулж Төсвийн байгууллагын удирдлага санхүүжлтийн тухай хуулийн *17.1.1. "Батлагдсан төсөв, бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээний хүрээнд зардал гаргах"* заалтыг зөрчсөн байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлт**

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлийн болзошгүй үр нөлөөг эс тооцвол Хотын төв номын сангийн 2012 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон санхүүгийн тайлангийн санхүүгийн байдлын, санхүүгийн үр дүнгийн, өмчийн өөрчлөлтийн, мөнгөн гүйлгээний тайлангууд нь Сангийн сайдын тушаалаар баталсан нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой журам, заавлын дагуу материаллаг зөрчилгүй илэрхийлэгдсэн байна.

НИЙСЛЭЛИЙН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ Т. САРАНТУЯА

УХА№122

# ХОТЫН ТӨВ НОМЫН САН

## 2012 оны санхүүгийн тайлан

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар харилцана уу:

Нийслэлийн Аудитын газар
Хангарьд Ордон-1001 тоот
Ш.Жигжиджавын гудамж 9
Чингэлтэй дүүрэг
Улаанбаатар-15160
Монгол улс

Web: www.city.audit.mn
e-mail: ub@audit.mn

Аудитын менежер:
Д.Энхдалай

Гэрээт аудит хариуцсан
Аудитор С.Гантөгс

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн:
"Б-энд -С" ХХК
Утас:70114810

Web: www.bcauditllc.mn

Захирал: Д.Дашхорлоо
Утас: 99099155
e-mail:
Dashkhorloo@yahoo.com

Аудитын багийн ахлагч:
Аудитор: Д.Дашхорлоо
Аудиторын туслах С.Хажид
mailto:naranbaatar@suld-audit.mn

АУДИТЫН КОД: СТА/01/14

# АУДИТЫН ДУУСВАР БОЛГОСОН ТУХАЙ ТАЙЛАН

АГУУЛГА — ХУУДАС

-Товчилсон үгийн жагсаалт 2
-Танилцуулга 2
-Санхүүгийн дотоод хяналтыг дахин шалгах 2
-Аудитын явцад илрүүлсэн гол зүйлс гаргасан шийдлүүд 3
-Залруулагдаагүй алдаа 3
-Тайлбар мэдүүлгийн захидал 3
-Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт 4
-Аудитын санал дүгнэлт 4
Хавсралт 1, Менежментийн захидал 5-8
Хавсралт 2, Аудит хийгдсэн санхүүгийн тайлан 8-13
Хавсралт 3,Санхүүгийн тайлангийн тодруулга 14-22
Хавсралт 4: Өмнөх зөвлөмжийн биелэлт 23

2012 оны 02 дугаар сарын 09

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

| | |
|---|---|
| ХТНС | Хотын төв номын сан |
| БСШУЯ | Боловсрол Соёл Шинжлэх ухааны яам |
| УСНББОУС | Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт |
| НББ | Нягтлан бодох бүртгэл |
| НАГ | Нийслэлийн аудитын газар |
| НДШ | Нийгмийн даатгалын шимтгэл |
| ХХОАТ | Хувь хүний орлогын албан татвар |

### Танилцуулга

Хотын төв номын сангийн 2012 оны 12 дугаар сарын 31-нээр тасалбар болгосон санхүүгийн тайланд аудит хийж дууссан тухай тайланг удирдлагад танилцуулж байна. Өмнө өгсөн Менежментийн захидалд санхүүгийн хяналтыг сайжруулахаар бидний өгсөн зөвлөмжүүд орсон бөгөөд удирдлага аудитаар илэрсэн асуудал, зөвлөмж бүрийг хүлээн зөвшөөрсөн байна.

Аудитор аудитад нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үйл ажиллагааг хамруулсан бөгөөд байж болзошгүй эрсдлийг тооцож аудитыг төлөвлөж, холбогдох батламж мэдэгдлүүд хэрхэн хангагдаж байгааг нотлох үүднээс холбогдох стандарт, журам заавтрын дагуу шаардлагатай аудитын горимуудыг дансдаас түүвэрлэж хэрэгжүүлэв.

Аудитад Хотын төв номын сангийн санхүүгийн тайлан болон тэдгээрийн гүйцэтгэлийг хамруулсан болно.

Нягтлан бодох бүртгэлийн боловсруулалт, төсөвт байгууллагад хэрэгжүүлж буй төсөв, бүртгэл, тайлагналын холбогдолтой хууль, журам, заавар, аргачлалын хэрэгжилт болон аудитын явцад илэрсэн сул талууд, түүнийг хэрхэн шийдвэрлэснийг дахин шалгах зэрэг ажлуудыг хийлээ.

### Нэг : Санхүүгийн дотоод хяналтыг дахин шалгах

Аудитор санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс санхүүгийн хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хяналаа. Ийнхүү хянахдаа хотын төв номын сангийн хэрэгжүүлж буй дотоод хяналтыг Б-энд-С ХХК-аас тооцож гаргасан санхүүгийн эрсдэл ба хяналтын байвал зохих горимтой харьцуулан шалгаж үзсэн. Үүний үр дүнд удирдлагаас зайлшгүй хэрэгжүүлэх дотоод хяналт ямар байгааг тогтоосон.

Аудитор энэ байгууллагын удирдлагад бүртгэл санхүүгийн үйл ажиллагаа, тайлагнал, дотоод хяналтад илэрсэн сул талуудыг тухай бүрт нь мэдэгдэж ажиллаа.

## Хоёр: Аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд

Өөрийн үйл ажиллагаанд холбогдох хууль, эрх зүйн актуудыг баримтлан санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараахь заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитор илэрсэн гол зөрчлүүдийг хотын төв номын сангийн удирдлагын анхааралд хандуулж байна.

### Асуудал 1: Төсвийн гүйцэтгэлийн талаар

Батлагдсан төсвийг 11,811.8 мянган төгрөгөөр хэтрүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 41. 2,2 “Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь

Цаашид төсвийг хэтрүүлэхгүйгээр Төсвийн тухай хуулийн 41. 2,2 “Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах,

## Гурав: Залруулагдаагүй алдаа

Аудитын стандарт нь аудитын явцад илэрсэн тодорхой биш болон залруулагдаагүй алдаанд анхаарал тавихыг шаарддаг. Эдгээр залруулагдаагүй алдаануудад энэ аудитад хамрагдсан байгууллагын удирдлага анхаарлаа хандуулж шийдвэрлэх шаардлагатай. Тухайлбал: Хууль, тогтоомжийн холбогдох заалтыг зөрчсөн 11,811.8 мянган төгрөгийн зөрчлийг номын сангийн удирдлагууд цаашид давтан гаргахгүй ажиллах нь зүйтэй.

## Дөрөв: Тайлбар мэдүүлгийн захидал

Б-энд-С Аудит ХХК нь хөндлөнгийн аудитын хувьд Хотын төв номын сангийн удирдлагын зүгээс гаргасан санхүүгийн тайлангийн бодит байдлын тухай мэдэгдэлд тулгуурлав. Аудитын явцад /тайлбар мэдүүлгийн захидлаар/ илэрсэн дутагдлын талаар санхүүгийн ажилтнуудаас тайлбар тодруулга авч бэлтгэсэн менежментийн захидлыг 2013 оны 02 дугаар сарын 26-ний 84 тоот албан бичгээр танай байгууллагын удирдлагад хүргүүлж, менежментийн захидлын хариуг 2013 оны 03 дугаар сарын 4ний 09 тоот албан бичгээр баталгаажуулан авч хавсаргав.

## Тав: Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

2012 оны 10 дугаар сарын 09 ний 49 тоотоор 2011 оны аудитын 2 зөвлөмжйг хэрэгжүүлэн ажилласан тухай ирүүлсэн болно.

## Зургаа: Аудитын санал дүгнэлт

Батлагдсан төсвийг 11,811.8 мянган төгрөгөөр хэтрүүснийг эс тооцвол Хотын төв номын сангийн 2012 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайлангийн санхүүгийн байдлын, санхүүгийн үр дүнгийн, өмчийн өөрчлөлтийн, мөнгөн гүйлгээний тайлангууд нь УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хууль, Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлал" дагуу илэрхийлэгдсэн гэж үзлээ.

# “ХОТЫН ТӨВ НОМЫН САН”

# 2012 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

## Менежментийн захидал

**...мэдээлэл авахыг хүсвэл**
**...хаягаар харилцана уу:**

...ерөнхий аудиторын
...
...
...: 327734

**Тэргүүлэх ач холбогдол №1 хуудас**

**Асуудал 1**

**Төсөвт зардал** **4**

...аудитын менежер
...
...аудит
...сан аудитор
...
...утас 315558

...аудитын газар
...баатар хот Чингэлтэй дүүрэг.
...жавын гудамж 9,
...ордон “ 1001 тоот
E-mail: ub@audit.mn Манай вэб
сайт : http://City.audit. mn

“Б энд С Аудит “ХХК
Захирал Д.Дашхорлоо
Утас:50880878
Гар утас:99833057
Аудиторын туслах: С,Хажид
Утас:70114810
“Б энд С Аудит” ХХК
ХУД Чингисийн өргөн чөлөө -13
ХЗАЗГ байр
2 давхарт

# Менежментийн захидал

## Нэг.Ерөнхий зүйл

### Аудит хийсэн үндэслэл хугацаа

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.2.1-д заасан бүрэн эрх, 18.2 дахь заалт, Нийслэлийн аудитын газартай байгуулсан гурван талт гэрээний дагуу хэрэгжүүлэх зорилгоор Төрийн аудитын тухай хуулийн 15.2.1-д заасан бүрэн эрхийн дагуу “Б энд С аудит ” ХХК Хотын төв номын сангийн жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлээ.

### Аудитын зорилт

Тус газрын 2012 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан УСНББОУС-ын болон холбогдох хууль эрхийн актын дагуу үнэн шударга илэрхийлэгдсэн үндэслэлтэй баталгаа олж, санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд толилуулахад энэхүү аудитын зорилт чиглэгдлээ.

### Аудитын хамарсан хүрээ

Хотын төв номын сангийн 2012 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг толилуулахдаа санхүүгийн тайланг иж бүрэн бөгөөд үнэн зөв болохыг тодорхойлсон батламж мэдэгдэл, тайлбар, нэмэлт тодруулгыг Аудитын олон улсын стандартын дагуу сорьж шалгалаа.

### Аудитын арга зүй

Хотын төв номын сангийн санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй баталгаа олж авахын тулд санхүүгийн тайланг бэлтгэхэд баримталсан бодлого, зарчмыг үнэлж, түүвэрлэсэн байдлаар аудитын шинжилгээний болон нарийвчилсан сорил хийж, ихээхэн дүнтэй ажил гүйлгээ, тооцооллыг давтан шалгаж, санхүүгийн тайлан, түүний тодруулгад үнэлгээ өгөв.

Ингэхдээ оршин байх, иж бүрэн байх, эрх үүрэг, тохиолдсон байх, үнэлгээ, хэмжилт, толилуулга, ба илчлэл, үнэн зөв байх зэрэг санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлийг шалгуур болголоо.

Манай гаргасан зөвлөмжүүд нь бидний хоорондын хамтын ажиллагааны үр дүн боловч тухайн зөвлөмжийг хэрэгжүүлэх нь тухайн байгууллагын удирдлагын үүрэг хариуцлага болно

**Хотын төв номын сангийн санхүүгийн тайлан гаргах аргачлал, бодлого**

"Хотын төв номын сан" Төсвийн тухай хуулийн 8.9.1 дэх заалтын дагуу тайланг 2012 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг тогтоосон хугацаанд бэлтгэжээ. Тус байгууллага Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны зааврыг баримталсан байна.

Байгууллагын төсвийн захирагчийн аккруэл сууриар бэлтгэсэн 2012 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дараах бүрэлдэхүүнтэй: Үүнд:

- Санхүүгийн байдлын тайлан
- Санхүүгийн үр дүнгийн тайлан
- Мөнгөн гүйлгээний тайлан
- Өмчийн өөрчлөлтийн тайлан
- Төсвийн гүйцэтгэлийн тайлан
- Тайлангийн тодруулгуудаас тус тус бүрджээ

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан хотын номын сангийн захирал Ө.Ган-Өлзий нягтлан бодогч Ц.Сарантуяа болон бусад ажилтнуудад талархал илэрхийлье

**Менежментийн захидалд дурдагдсан зүйлсийг ач холбогдлынх нь дараалаар дурьдвал:**

**Тэргүүлэх ач холбогдол**

**Асуудал 1: Зардал**

Бодит байдал

Нийт дүнгээрээ 53,486.9 мянган төгрөгөөр хэтрүүлсэн харагдаж байгаа ч Сангийн сайдын 2007 оны 11 тоот тушаалаар батлагдсан "Төсвийн байгууллагын үйл ажиллагааны нэмэлт орлого болон зардлын хэмнэлтийг тооцох, зарцуулах, тайлагнах журам"-ын дагуу давсан орлогыг дараа жилд хууль журмын дагуу зарцуулах эрхийн дагуу зарцуулсан 41,675.1 мянган төгрөгийг хасаж 11,811.8 мянган төгрөгөөр төсвийг хэтрүүлсэн нь Төсвийн тухай хууль 41.2.2 "Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

*Эрсдэл*

*Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхгүй байх*

*Зөвлөмж*

Цаашид төсвийг хэтрүүлэхгүйгээр Төсвийн тухай хууль 41.2,2 “Батлагдсан төсвийн хэмжээнд зарлага гаргах” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах

*Үйлчлүүлэгчийн хариу*

Тус байгууллагын 2012 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар 11,811.8 мянган төгрөгийн төсвийн хэтрэлттэй гарсан. Энэ хэтрэлт нь 2012 оны ажиллагсдын хоол, унааны хөнгөлөлтийн мөнгийг төсвийн төлөвлөгөөнд дутуу төсөвлөсөн байсантай холбоотой бөгөөд тооцоо судалгааг холбогдох байгууллагад хүргүүлснээр 2012 оны 04 дүгээр сард нэмж төсөвлөгдсөн. Иймээс дээрх хэтрэлттэй гарсан 11,811.8 мянган төгрөгийг төлбөрт үйлчилгээний орлогоос ажиллагсдын хоол унааны мөнгөнд олгосон болно.

Тус номын сан нь 2012 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар харилцах дансанд 27,997.4 төгрөгийн үлдэгдэлтэй гарсан.

Бид цаашид зөвлөмжид дурдагдсан мөнгийг гаргахгүй байхыг онцгой анхаарч, зөрчлийг арилгаж ажиллана.

## ХОТЫН ТӨВ НОМЫН САН АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

| ҮЗҮҮЛЭЛТ | 2011.12.31 | 2012.12.31 |
|---|---|---|
| **МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ** | **41 710 837,33** | **8 875,95** |
| Жижиг мөнгөн сан | 35 002,95 | 8 875,95 |
| Банкинд байгаа бэлэн мөнгө / төгрөгөөр/ | 41 675 834,38 | |
| **АВЛАГА** | **791 760,95** | **-** |
| Бусад авлага | 791 760,95 | |
| **БАРАА МАТЕРИАЛ** | **12 538 210,35** | **14 159 470,35** |
| Хангамжийн материал | 5 660 612,50 | 5 897 062,50 |
| Бусад | 6 877 597,85 | 8 262 407,85 |
| **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **55 040 808,63** | **14 168 346,30** |
| **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ** | | |
| **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **1 777 678 516,83** | **1 904 481 880,55** |
| Барилга, байгууламж | 2 778 096 400,00 | 2 778 096 400,00 |
| Хуримтлагдсан элэгдэл | (1 458 445 763,00) | (1 510 921 874,48) |
| Авто-тээврийн хэрэгсэл | 55 000 000,00 | 140 600 000,00 |
| Хуримтлагдсан элэгдэл | (52 143 055,80) | (55 713 333,33) |
| Машин, тоног төхөөрөмж | 113 711 357,80 | 189 659 557,80 |
| Хуримтлагдсан элэгдэл | (78 486 335,48) | (101 563 594,18) |
| Тавилга, аж ахуйн эд хогшил | 187 677 581,00 | 211 898 207,00 |
| Хуримтлагдсан элэгдэл | (150 777 387,32) | (166 989 511,89) |
| Номын фонд | 380 342 377,51 | 417 392 787,51 |
| Бусад үндсэн хөрөнгө | 5 440 800,00 | 5 440 800,00 |
| Хуримтлагдсан элэгдэл | (2 737 457,88) | (3 417 557,88) |
| **Биет бус хөрөнгө** | **-** | |
| Программ хангамж | 980 000,00 | 980 000,00 |
| Хуримтлагдсан элэгдэл | (980 000,00) | (980 000,00) |
| **БУСАД ХӨРӨНГӨ** | **-** | |

| | | |
|---|---|---|
| **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1 777 678 516,83** | **1 904 481 880,55** |
| **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **1 832 719 325,46** | **1 918 650 226,85** |
| Засгийн газрын хувь оролцоо | 1 317 350 926,22 | 1 508 294 217,22 |
| Хуримтлагдсан үр дүн | (200 629 952,65) | (299 808 619,36) |
| Өмнөх үеийн үр дүн | (200 629 952,65) | (194 796 229,75) |
| Тайлант үеийн үр дүн | 0,00 | (105 012 389,61) |
| Дахин үнэлгээний зөрүү | 715 998 351,89 | 710 164 628,99 |
| **ЦЭВЭР ХӨРӨНГӨ / ӨМЧИЙН ДҮН** | **1 832 719 325,46** | **1 918 650 226,85** |
| **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ / ӨМЧИЙН ДҮН** | **1 832 719 325,46** | **1 918 650 226,85** |

Баталгаажуулсан Аудитор: Д.Дашхорлоо
Менежер Ө.Ган-Өлзий
Нягтлан бодогч Ц.Сарантуяа

## ХОТЫН ТӨВ НОМЫН САН АУДИТЛАГДСАН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

| ҮЗҮҮЛЭЛТ | 2011.12.31 | 2012.12.31 |
|---|---|---|
| Урсгал | 494 634 300,00 | 743 958 925,62 |
| Бусад төсөвт байгууллагаас | 29 984 900,00 | 0,00 |
| Төслийн орлого | **4 028 894,00** | 0,00 |
| Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлого | 95 222 828,89 | 69 782 333,00 |
| Үйл ажиллагааны орлоын дүн | **623 870 922,89** | **813 741 258,62** |
| Ажиллагчидтай холбогдсон зардал | **382 718 145,24** | **600 895 267,62** |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал | **347 866 603,72** | **551 306 733,97** |
| Цалин | **347 866 603,72** | 551 306 733,97 |
| Нийгмийн хамгааллын шимтгэл | **33 631 483,48** | **49 588 533,65** |
| Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл | **33 591 236,45** | 49 588 533,65 |
| Эрүүл мэндийн даатгалын хураамж | 40 247,03 | 0,00 |
| **Бараа үйлчилгээний урсгал зардал** | **231 399 640,45** | **314 476 372,56** |
| **Тогтмол зардал** | **87 946 791,72** | **83 632 628,00** |
| Гэрэл цахилгааны зардал | **28 334 699,00** | 24 636 284,00 |
| Түлш, халаалтын зардал | 54 661 087,72 | 54 466 196,94 |
| Цэвэр, бохир усны зардал | 4 951 005,00 | 4 530 147,06 |
| **Үйл ажиллагааны зардал** | **5 560 529,80** | **8 666 380,00** |
| Эм | 5 560 529,80 | 8 666 380,00 |
| **Бусад бараа үйлчилгээний зардал** | **137 892 318,93** | **222 177 364,56** |
| Бичиг хэргийн материал | **1 624 380,00** | 1 417 650,00 |
| Тээвэр, шатахууны зардал | 1 242 400,00 | 6 858 700,00 |
| Шуудан холбооны зардал | 1 195 916,40 | 1 819 840,00 |
| Дотоод томилолтын зардал | 0,00 | 312 000,00 |
| Гадаад томилолтын зардал | 0,00 | 0,00 |
| Ном, хэвлэлийн зардал | 1 706 047,00 | 3 736 870,00 |
| Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал | 0,00 | 200 000,00 |
| Сургалт семинарын зардал | 2 585 050,00 | 290 600,00 |
| Жижиг эд хогшил худалдан авах зардал | 0,00 | 3 264 730,00 |
| Зөөлөн эдлэл, нормын хувцас худалдан авах зардал | 125 000,00 | 275 500,00 |
| Төлбөр, хураамж, жижиг татварууд | 16 166 950,00 | 3 159 730,00 |

| | | |
|---|---|---|
| Түлшний зардал | 4 213 770,00 | 0,00 |
| Бусдын өмнөөс гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр | 635 710,00 | 490 000,00 |
| Бусад | 9 925 258,00 | 3 052 900,00 |
| Урсгал засварын зардал | 1 615 000,00 | 7 892 874,00 |
| Нэг удаагийн тэтгэмж урамшуулал | 0,00 | 20 019 822,00 |
| Элэгдлийн зардал | 93 520 837,53 | 98 193 329,23 |
| Биеийн тамирын уралдаан тэмцээн | 0,00 | 2 626 100,00 |
| Элэгдэлийн зардал | 0,00 | |
| Бусад зардал | | 791 760,95 |
| Хөтөлбөр арга хэмжээний зардал | 3 336 000,00 | 67 774 958,38 |
| **Үйл ажиллагааны зардлын дүн** | **612 897 727,65** | **915 371 640,18** |
| **Үйл ажиллагааны үр дүн** | **10 973 195,24** | **(101 630 381,56)** |
| **Хөрөнгө худалдсны гарз** | | 3 382 008,05 |
| **Үйл ажиллагааны бус зардлын дүн** | | 3 382 008,05 |
| **Үйл ажиллагыын нийт үр дүн** | | (105 012 389,61) |

Баталгаажуулсан Аудитор: Д.Дашхорлоо
Менежер Ө.Ган-Өлзий
Нягтлан бодогч Ц.Сарантуяа

## ХОТЫН ТӨВ НОМЫН САН АУДИТЛАГДСАН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

| ҮЗҮҮЛЭЛТ | 2011.12.31 | 2011.12.31 |
|---|---|---|
| **ТАТААС, САНЖҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **524 619 200,00** | **743 958 925,62** |
| Улсын төсвөөс | 494 634 300,00 | 743 958 925,62 |
| Орон нутгийн төсвөөс | 29 984 900,00 | 0,00 |
| **Бараа, үйлчилгээний орлого** | **95 222 828,89** | **69 782 333,00** |
| Өмчийн орлого | 0,00 | 0,00 |
| Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлого | 36 438 871,00 | 49 254 487,00 |
| Үндсэн үйл ажиллагааны орлого | | 0,00 |
| Бусад орлого | 58 783 957,89 | 20 527 846,00 |
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН** | **619 842 028,89** | **813 741 258,62** |
| **АЖИЛЛАГЧИДТАЙ ХОЛБОГДСОН ЗАРДАЛ** | **372 148 774,00** | **597 994 310,62** |
| **Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил** | ***335 297 804,00*** | ***538 786 237,62*** |
| Цалин | 335 297 804,00 | 538 786 237,62 |
| Цалингийн тусгай нэмэгдлүүд | 0,00 | 0,00 |
| **Нийгмийн хамгааллын шимтгэл** | **36 850 970,00** | **59 208 073,00** |
| Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл | 28 136 970.00 | 52 780 873,00 |
| Тэтгэмжийн даатгалын шимтгэл | 2 900 000.00 | 6 427 200,00 |
| Эрүүл мэндийн даатгалын шимтгэл | 5 814 000,00 | |
| **БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ УРСГАЛ ЗАРДАЛ** | **206 883 057,12** | **257 448 909,38** |
| **Тогтмол зардал** | **87 946 791,72** | **91 066 943,00** |
| Гэрэл цахилгааны зардал | 28 314 699,00 | 27 051 520,00 |

| | | |
|---|---|---|
| Түлш, халаалтын зардал | 54 261 087,72 | 59 959 322,94 |
| Цэвэр, бохир усны зардал | 4 951 005,00 | 4 056 100,06 |
| **Бусад бараа үйлчилгээний зардал** | **119 356 265,40** | **166 381 966,38** |
| Бичиг хэргийн материал | 3 732 907,00 | 3 642 280,00 |
| Тээвэр, шатахууны зардал | 481 400,00 | 360 300,00 |
| Шуудан холбооны зардал | 995 916,40 | 1 346 840,00 |
| Дотоод томилолтын зардал | 832 500,00 | 1 182 000,00 |
| Ном, хэвлэлийн зардал | 31 423 292,00 | 40 180 440,00 |
| Сургалт семинарын зардал | 75 800,00 | 200 000,00 |
| Жижиг эд хогшил худалдан авах зардал | 2 100 000,00 | 4 020 490,00 |
| Зээлэн эдлэл, нормын хувцас худалдан авах зардал | 2 188 850,00 | 3 409 000,00 |
| Төлбөр, хураамж, жижиг татварууд | 27 844 492,00 | 4 391 530,00 |
| Төслийн зардал | 102 300,00 | 0,00 |
| Харуул хамгаалалтын зардал | | 620 000,00 |
| Урсгал засварын зардал | 3 303 640,00 | 8 992 874,00 |
| Биеийн тамирын уралдаан, тэмцээний зардал | | 1 576 100,00 |
| Бусад зардал | 5 038 410,00 | 1 056 840,00 |
| Хог хаягдал устгах цэвэрлэх | 0,00 | 8 670 650,00 |
| **Хөтөлбөр арга хэмжээний зардал** | **29 984 900,00** | **0,00** |
| **Нийгмийн хамгааллын зардал** | **10 351 258,00** | **86 732 622,38** |
| Бусад татаас шилжүүлэг | 0,00 | 41 675 834,38 |
| Нэг удаагийн тэтгэмж урамшуулал | 10 351 258,00 | 28 281 424,00 |
| Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | | 16 775 364,00 |
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (II)** | **579 031 831,12** | **855 443 220,00** |
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **40 810 197,77** | **(41 701 961,38)** |
| **САНХҮҮГИЙН АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (IX)=(VII)+(VIII)** | **40 810 197,77** | **(41 701 961,38)** |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | **900 639,56** | **41 710 837,33** |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | **41 710 837,33** | **8 875,95** |

Баталгаажуулсан Аудитор: Д.Дашхорлоо
Менежер: Ө.Ган-Өлзий
Нягтлан бодогч: Ц.Сарантуяа

## ХОТЫН ТӨВ НОМЫН САН АУДИТЛАГДСАН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

| ҮЗҮҮЛЭЛТ | | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| Аудиталсан дүн | 2011 оны 12-р сарын 31 -ээрх үлдэгдэл | | | | |
| | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | | (5 833 722,90) | | (5 833 722,90) |
| | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 190 943 291,00 | | 5 833 722,90 | 196 777 013,90 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Тайлант үеийн үр дүн | | | (105 012 389,61) | (105 012 389,61) |
| 2011 оны 12-р сарын 31 -ээрх үлдэгдэл | 1 508 294 217,22 | 710 164 628,99 | (299 808 619,36) | 1 918 650 226,85 |

Баталгаажуулсан Аудитор: Д.Дашхорлоо
Менежер : Ө.Ган-Өлзий
Нягтлан бодогч: Ц.Сарантуяа

## ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

| Эдийн засгийн ангилал | төлөвлөгөө | гүйцэтгэл | Зөрүү |
|---|---|---|---|
| | | | хэтрэлт. хэмнэлт |
| **I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **801 956 300,0** | **855 443 220,00** | **(53 486 920,0)** |
| **Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил** | **538 647 800,0** | **538 786 237,6** | **(138 437,6)** |
| Үндсэн цалин | 538 647 800,0 | 538 786 237,62 | **(138 437,6)** |
| **Нийгмийн хамгааллын шимтгэл** | **59 251 200,0** | **59 208 073,0** | **43 127,0** |
| Тэтгэврийн даатгал | 59 251 200,0 | 59 208 073,00 | **43 127,0** |
| БАРАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ УРСГАЛ ЗАРДАЛ | **204 057 300,0** | **257 448 909,38** | **(53 391 609,4)** |
| Гэрэл цахилгааны зардал | 27 415 400,0 | 27 051 520,00 | 363 880,00 |
| Түлш, халаалтын зардал | 59 959 900,0 | 59 959 322,94 | 577,06 |
| Цэвэр, бохир усны зардал | 4 377 200,0 | 4 056 100,06 | 321 099,94 |
| Бичиг хэргийн зардал | 2 640 000,00 | 3 642 280,00 | **(1 002 280,0)** |
| Тээвэр, шатахууны зардал | 436 100,00 | 360 300,00 | 75 800,00 |
| Шуудан холбооны зардал | 1 325 000,00 | 1 346 840,00 | **(21 840,0)** |
| Дотоод | 1 191 000,00 | 1 182 000,00 | 9 000,00 |
| Ном, хэвлэлийн зардал | 40 000 000,0 | 40 180 440,00 | **(180 440,0)** |
| Жижиг эд хогшил худалдан авах зардал | 4 050 000,0 | 4 020 490,00 | 29 510,00 |
| Зөөлөн эдлэл, нормын хувцас худалдан авах зардал | 3 500 000,0 | 3 409 000,00 | 91 000,00 |
| Төлбөр хураамж бусад зардал | 4 187 500,0 | 47 944 204,38 | **(43 756 704,4)** |
| Хог хаягдал устгах зардал | 8 640 000,0 | 8 670 650,00 | **(30 650,0)** |
| Урсгал засварын зардал | 9 000 000,0 | 8 992 874,00 | 7 126,00 |
| Биеийн тамир уралдаан тэмцээн | 1 500 000,0 | 1 576 100,00 | **(76 100,0)** |
| Тэтгэвэрт гарах хүний тэтгэмж | 30 935 200,0 | 16 775 364,00 | 14 159 836,00 |
| Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал | 4 900 000,0 | 28 281 424,00 | **(23 381 424,0)** |
| **VI. ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **801 956 300,0** | **813 741 258,6** | **(11 784 958,6)** |
| Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 30 000 000,0 | 69 782 333,00 | **(39 782 333,0)** |
| Төсвөөс санхүүжих | 771 956 300,0 | 743 958 925,62 | **27 997 374,4** |
| Мөнгөн хөрөнгийн оны эцсийн үлдэгдэл | | 8 875,95 | **(8 876,0)** |
| БАЙГУУЛЛАГЫН ТОО | 5,0 | 5,0 | **0,0** |
| АЖИЛЛАГСАД БҮГД | 82,0 | 82,0 | **0,0** |
| Удирдах ажилтан | 6,0 | 6,0 | **0,0** |
| Гүйцэтгэх ажилтан | 42,0 | 42,0 | **0,0** |
| Үйлчлэх ажилтан | 34,0 | 34,0 | **0,0** |

Баталгаажуулсан Аудитор: Д.Дашхорлоо
Менежер: Ө.Ган-Өлзий
Нягтлан бодогч: Ц.Сарантуяа

**2012 оны 12-р сарын 31-нээр дуусгавар болгосон санхүүгийн тайланд аудит хийсэн тодруулга, тэмдэглэл**

## 1. ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГАА

Д.Нацагдоржийн нэрэмжит Улаанбаатар Хотын Нийтийн Төв Номын Сан нь 1980 онд ЗХУ-ын /хуучин нэрээр/ техник эдийн засгийн тусламжтайгаар баригдаж ашиглалтанд оржээ. БНМАУ-ын АИХТ-ийн 1986 оны 11 дүгээр сарын 17-ны 207 тоот зарлигаар их зохиолч Д.Нацагдоржийн нэрэмжит болсон юм.1986 оноос дүүрэг, хороо, улаанбулан, соёлын төвийн дэргэдэх нийтийн 15 орчим номын сангуудыг төвлөрүүлэлтийн тогтолцоонд шилжүүлжээ. Хотын нийтийн төв номын сан нь 3 тасаг, Хан-уул, Сонгино хайрхан, Баянзүрх, Чингэлтэй дүүргүүдэд үйл ажиллагаагаа явуулж байна.

Төрийн чиг үүргийн дагуу уншлага үйлчилгээ, интернэт мэдээллийн үйлчилгээ, мэдээллийн нөөц бүрдүүлэх лавлагаа ном зүйн үйлчилгээ, сэлбэн засах үйлчилгээ, гэрээр олгох үйлчилгээ, хэрэглэгчдэд интернэтийг хэрхэн явуулах талаар сургалт явуулах, ЕБС-ийн номын санчдад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх зэрэг чиг үүргийг хэрэгжүүлдэг байна.

Номын сангуудыг орчин үеийн номын сан мэдээллийн төв болгох зорилт дэвшүүлэн техник технологиор хангах зорилгыг агуулсан том жижиг төслүүдийг боловсруулж, Монголд хандивлагчдын зөвлөгөөнд оруулснаар 306000$-ийн төсөл 1998-2010 онд хэрэгжсний үр дүнд олон улсын жишигт нийцсэн номын сан болсон гэж үздэг байна.

Номын фонд 600000 орчим боть номтой, 70 хувь нь монгол, 35 хувь нь орос, үлдсэн нь бусад орны номтой, нийт 82 ажиллагсадтай үйл ажиллагаагаа явуулж байна.

## 2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГО ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТ

Тус байгууллага нь төсөвт байгууллагын НББ-ийн VINNICA программыг 2006 оноос хойш ашиглаж байна.Тус байгууллага нь холбогдох эрх бүхий дээд байгууллагаас гаргасан заавар, дүрэм, журам, тогтоол шийдвэрүүдээр гарсан өөрчлөлт бүрийг цаг тухай бүрт нь программ дээрээ хийлгэж байна.

НББ-ийн бодлогын баримт бичигтэй байх зайлшгүй шаардлага нь Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон түүнтэй нийцүүлэн эрх бүхий байгууллагаас гаргасан холбогдох заавар журам заалтыг хэрэгжүүлэх зорилгоор 2007 онд НББ-ийн бодлогын бичиг баримтыг боловсруулж хэрэгжүүлэн ажиллаж байна.

**а. Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө**

Хотын төв номын сангийн мөнгөн хөрөнгө нь касс болон төрийн сангийн харилцах дансан дахь төгрөг, түүнтэй адилтгах зүйлсээс бүрдэнэ. Бусад орны мөнгөн тэмдэгт болох гадаад валютаар хийгдсэн ажил гүйлгээ гарвал тухайн үеийн Монгол банкнаас зарласан албан ханшаар бүртгэдэг.

**б. Бараа материал**

Бараа материалыг агуулахад хүлээн авсан үед нь худалдан авсан үнээр нь бараа материалын дансанд бүртгэдэг. Бараа материалыг эхэлж авснаа эхэлж зарлагадах аргаар зарлага болгож, байнгын бүртгэлийн системээр бүртгэдэг.

**в. Үндсэн хөрөнгө ба элэгдэл**

Үндсэн хөрөнгийг анхны худалдан авалтын өртгөөр нь бүртгэдэг. Үндсэн хөрөнгийг тооцоолсон ашиглалтын хугацааны туршид байгууллагын үндсэн хөрөнгийн элэгдлийн хувь, элэгдэл байгуулах тухай Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 11-р сарын 23-ны өдрийн 233 дугаар тогтоолоор элэгдүүлдэг.
Тус байгууллагын үндсэн хөрөнгийн ашиглагдах хугацаа нь дараахь байдалтай:

| Үндсэн хөрөнгө | Ашиглагдах хугацаа |
|---|---|
| Барилга байгууламж | 60 жил |
| Машин тоног төхөөрөмж | 6 жил |
| Тавилга эд хогшил, багаж хэрэгсэл | 10 жил |
| Компьютер, тооцоолох техник | 5 жил |

Биет бус хөрөнгийн ашиглалтын хугацааг хөрөнгийн онцлог шинж чанарыг харгалзан тодорхойлох ба шууд аргаар элэгдүүлдэг.

**г. Татвар, шимтгэл**

- Ажилчид, ажиллагсдын цалингаас сар бүр ногдох ХХОАТ-ын хуулийн 11.1.1-т зааснаар сар бүр тооцоо хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд өр авлагын үлдэгдэлгүй гарсан байна.
- ЭМД, НДШимтгэлийн тооцоог сар бүр хийж үлдэгдэлгүй тайлагнагдсан байна.

**Тайлан тэнцлийн талаархи тайлбар:**

**1 МӨНГӨН ХӨРӨНГӨ:**

| Нярвын овог нэр | Валютын төрөл | Тоо | Тооллогоор | Тайлант оны эцсийн үлдэгдэл | Илүүдсэн /Дутсан/ | Өмнөх оны эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|---|---|---|
| Т.Шинээ | төгрөг | | | 8,875.95 | (26 127,00) | 35,002.95 |
| **Дүн** | | **0** | | 8,875.95 | (26 127,00) | 35,002.95 |

Жижиг мөнгөн сангийн тооцоог бодож үүдэглийг баталгаажуулсан байна.

## 2. Банкин дахь харилцахын үлдэгдэл

| Банкны нэр, дансны дугаар | Валютын төрөл | Тоо хэмжээ | Мөнгөн дүн | Тайлбар |
|---|---|---|---|---|
| Төрийн сан ( ) | Төгрөг | 0 | - | |

| Дансны нэр | эхний үлдэгдэл | Нэмэгдсэн | Хасагдсан | эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|---|
| Төсөвт байгууллагын харилцах | 41 675 834,38 | 743 958 925,62 | 785 634 760,00 | - |
| Касс- Жижиг мөнгөн сан | 35 002,95 | 69 782 333,00 | 69 808 460,00 | 8 875,95 |
| Мөнгөн хөрөнгийн дүн | 41 710 837,33 | 813 741 258,62 | 855 443 220,00 | 8 875,95 |

Тайлант онд мөнгөн хөрөнгийн дансанд төсвийн санхүүжилтээр 743,958.9 мянган төгрөг, үндсэн ба туслах үйл ажиллагааны орлогоор 69,782.3 мянган төгрөг нийт 813,741.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж 855,443.2 мянган төгрөгний зардал гаргасан байна. Мөнгөн хөрөнгийн журналаас түүвэрлэлт хийж анхан шатны баримт руу хөөн шалгахад анхан шатны баримт бүрэн, холбогдох албан тушаалтнууд гарын үсэг зурж баталгаажуулснаар ажил гүйлгээ хийгдсэн байна.

Сангийн сайдын 2012 оны 295 тоот тушаалаар төсвийн харилцах дансны үлдэгдлийг төвлөрүүлж дээрхи үлдэгдэлтэй гарсан байна.

Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл Төрийн сангийн банкны харилцахын үлдэгдлийн баталгаатай тохирч байна.

## 3.Авлага

| Дансны нэр | эхний үлдэгдэл | Нэмэгдсэн | Хасагдсан | эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|---|

| | | | | |
|---|---|---|---|---|
| Ажиллагсадтай холбогдсон авлага | 791 760,95 | - | 791 760,95 | - |
| Авлагын дүн | 791 760,95 | - | 791 760,95 | - |

Тайлант жилийн авлагын эхний үлдэгдэл буюу 791,760.95 төгрөг нь ажилчдаас авах номын өр төлбөрын авлагыг тайлангийн жилд хассан байна.

**4.Өглөг**

| Дансны нэр | эхний үлдэгдэл | Нэмэгдсэн | Хасагдсан | эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|---|
| Ажиллагчидтай холбогдсон өглөг | 0 | 3 835 894,00 | 3 835 894,00 | |
| Цалингийн өглөг | 0 | 551 238 838,35 | 551 238 838,35 | |
| Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг | 0 | 92 309 416,00 | 92 309 416,00 | |
| ХАОАТ-ын өглөг | 0 | 4 528 147,06 | 4 528 147,06 | - |
| Номын өглөг | 0 | 924 210,00 | 924 210,00 | - |
| Нийт дүн | | 652 836 505,41 | 652 836 505,41 | |

**5.Бараа, материал**

| Үзүүлэлт | эхний үлдэгдэл | Нэмэгдсэн | Хасагдсан | эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|---|
| Бичиг хэргийн материал | 40 000,00 | | | 40 000,00 |
| Хангамжийн материал | 5 620 612,50 | 3 045 730,00 | 2 809 280,00 | 5 857 062,50 |
| Нөөцийн материал | 6 877 597,85 | 7 111 410,00 | 5 726 600,00 | 8 262 407,85 |
| дүн | 12 538 210,35 | 10 157 140,00 | 8 535 880,00 | 14 159 470,35 |

Тайлант онд бараа материал оны эхний үлдэгдлээс 1,621.3 мянган төгрөгөөр өссөн байна. Төсвийн хөрөнгөөр 10,157.1 мянган төгрөгний бараа материал худалдан авч, 8,535.9 мянган төгрөгний бараа материал зарцуулсан байна. Төсөвт байгууллагын НББ, санхүүгийн тайлангийн аргачлал, зааварын 4.22-д “Төсөвт байгууллага нь бараа материалын өртгийг тодорхойлохдоо эхэлж авсныг эхэлж зарлагадах (ЭАЭЗ) аргыг ашиглана” гэсэн заалтын дагуу зарцуулжээ.

**6.Үндсэн хөрөнгө**

Балансын өдрөөрх байгууллагын үндсэн хөрөнгө дараахь байдалтай байна.

| Үзүүлэлт | эхний үлдэгдэл | Нэмэгдсэн | Хасагдсан | эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|---|
| Барилга | 2 778 096 400,00 | | | 2 778 096 400,00 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Тээврийн хэрэгсэл | 55 000 000,00 | 85 600 000,00 | | 140 600 000,00 |
| Тоног төхөөрөмж | 113 711 357,80 | 75 948 200,00 | | 189 659 557,80 |
| Тавилга эд хогшил | 187 677 581,00 | 29 780 091,00 | 5 559 465,00 | 211 898 207,00 |
| Номын фонд | 380 342 377,50 | 37 050 410,00 | | 417 392 787,50 |
| Бусад үндсэн хөрөнгө | 5 440 800,00 | | | 5 440 800,00 |
| Биет бус хөрөнгө | 980 000,00 | | | 980 000,00 |
| ДҮН | 3 521 248 516,30 | 228 378 701,00 | 5 559 465,00 | 3 744 067 752,30 |

- Тээврийн хэрэгсэлд: БСШУЯ-ны хөрөнгө оруулалтаар УАЗ фургон маркийн 4 ш авто машин 85,600.0 мянган төгрөг, нүүдлийн номын сангийн зориулалтаар нэг бүр нь 21,400.0 мянган төгрөгийн үнэтэй.
- Тоног төхөөрөмжид: Улсын төсвөөс БСШУЯ –ны хөрөнгө оруулалтаар 71,685.5 мянган төгрөг, эмэгтэйчүүд сангийн хандиваар 4,262.7 мянга, нийт 75,948.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.
- Тавилга эд хогшилд: өөрийн хөрөнгөөр 385,0 мянган төгрөг, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 29,395.1 мянган төгрөг нийт 29,780.0 мянган төгрөг,
- Ном фондод: төсвийн хөрөнгөөр 37,050.0 мянган төгрөгийн ном худалдан авч бэлтгэжээ.
- Төсвийн хөрөнгөөр 37,435.4 мянга, хөрөнгө оруулалтаар 186,680.6 мянга, хандив тусламжаар 4,262.7 мянга, нийт 228,378.7 мянган төгрөгийн хөрөнгийг ***НӨХГ-ын даргын 2012 оны 12 сарын 06-ны өдрийн А/663 тоот тушаал болон зохих журмын дагуу бүртгэн авсан байна.***
- Нийслэлийн өмчийн харилцааны газрын даргын 2012 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн А/611 тоот тушаалаар Тавилга эд хогшил 5,554.6 мянган төгрөгөөр актлагдаж хасагдсан байна.

## 7,Үндсэн хөрөнгийн элэгдэл

| Дансны нэр | эхний үлдэгдэл | Нэмэгдсэн | Хасагдсан | эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|---|
| Барилга байгууламж | 1 458 445 763,00 | 52 476 111,48 | | 1 510 921 874,48 |
| Биет бус хөрөнгө | 980 000,00 | | | 980 000,00 |
| Тоног төхөөрөмж | 78 486 335,48 | 23 077 258,70 | | 101 563 594,18 |
| Тавилга хэрэгсэл | 150 777 387,32 | 18 389 581,52 | 2 177 456,95 | 166 989 511,89 |
| Авто тээврийн хэрэгсэл | 52 143 055,80 | 3 570 277,53 | - | 55 713 333,33 |
| Номын фонд | | | | - |
| Программ хангамж | 2 737 457,88 | 680 100,00 | | 3 417 557,88 |
| **Дүн** | **1 743 569 999,48** | **98 193 329,23** | **2 177 456,95** | **1 839 585 871,76** |

Засгийн газрын 2005 оны 11-р сарын 23-ны 233 тоот тогтоолоор батлагдсан "Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох журам" ба "Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцоход баримтлах хугацаа, жилд байгуулах элэгдлийн хэмжээ" –г баримтлан үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох шулуун шугамын аргаар 98,193.3 мянган төгрөгийн элэгдлийг байгуулжээ.

## 7. Цэвэр хөрөнгө (өмчийн дүн)

| Үзүүлэлт | эхний үлдэгдэл | Нэмэгдсэн | Хасагдсан | эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|---|
| Засгийн газрын хувь оролцоо | 1 317 350 926,22 | 187 561 282,95 | | 1 504 912 209,17 |
| Хуримтлагдсан үр дүн | (200 629 952,65) | 5 833 722,90 | 101 630 381,56 | (296 426 611,31) |
| Дахин үнэлгээний зөрүү | 715 998 351,89 | | 5 833 822,90 | 710 164 528,99 |
| **НИЙТ ДҮН** | **1 832 719 325,46** | **193 395 005,85** | **107 464 204,46** | 1 918 650 126,85 |

2012 оны санхүүгийн жилд хотын төв номын сангийн хуримтлагдсан үр дүн сөрөг үзүүлэлттэй (200,629.9) мянган төгрөг байсан 296,426.6 мянган төгрөг болж, 95,796.6 мянган төгрөгөөр тайлант үеийн үр нэмэгджээ.

## 8.Үйл ажиллаганы орлого, зардал

| ЭДИЙН ЗАСГИЙН АНГИЛАЛ | ӨНГӨРСӨН ОНЫ ГҮЙЦЭТГЭЛ | ТӨЛӨВЛӨГӨӨ | ГҮЙЦЭТГЭЛ | Тайлант оны өөрчлөлт | | өнгөрсөн онтой харьцуулсан өөрчлөлт | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Дүн | хувь | Дүн | хувь |
| **ЗАРДАЛ** | 526 787 923,62 | 801 956 300,00 | 855 443 220,00 | (53 486 920,00) | 106,67 | 328 655 296,38 | 162,4 |
| Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 296 272 799,00 | 597 899 000,00 | 597 994 310,62 | (95 310,62) | 100,02 | 301 721 511,62 | 201,8 |
| Үндсэн цалин | 267 638 633,00 | 538 647 800,00 | 538 786 237,62 | (138 437,62) | 100,03 | 271 147 604,62 | 201,3 |
| Нийгмийн хамгааллын шимтгэл | 28 634 166,00 | 59 251 200,00 | 59 208 073,00 | 43 127,00 | 99,93 | 30 573 907,00 | 206,8 |
| **БАРАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ УРСГАЛ ЗАРДАЛ** | 230 515 124,62 | 204 057 300,00 | 257 448 909,38 | (53 391 609,38) | 126,17 | 26 933 784,76 | 111,7 |
| Гэрэл цахилгааны зардал | 32 939 271,00 | 27 415 400,00 | 27 051 520,00 | 363 880,00 | 98,67 | (5 887 751,00) | 82,1 |
| Түлш, халаалтын зардал | 53 508 501,00 | 59 959 900,00 | 59 959 322,94 | 577,06 | 100,00 | 6 450 821,94 | 112,1 |
| Цэвэр, бохир усны зардал | 5 185 762,00 | 4 377 200,00 | 4 056 100,06 | 321 099,94 | 92,66 | (1 129 661,94) | 78,2 |
| Бичиг хэргийн зардал | 16 081 178,00 | 2 640 000,00 | 3 642 280,00 | (1 002 280,00) | 137,97 | (12 438 898,00) | 22,6 |
| Тээвэр, шатахууны зардал | 1 574 498,00 | 436 100,00 | 360 300,00 | 75 800,00 | 82,62 | (1 214 198,00) | 22,9 |
| Шуудан холбооны зардал | 2 650 698,55 | 1 325 000,00 | 1 346 840,00 | (21 840,00) | 101,65 | (1 303 858,55) | 50,8 |
| Гадаад томилолтын зардал | 3 508 340,00 | | | | | (3 508 340,00) | 0,0 |
| Дотоод | 965 000,00 | 1 191 000,00 | 1 182 000,00 | 9 000,00 | 99,24 | 217 000,00 | 122,5 |
| Ном, хэвлэлийн зардал | 19 487 733,00 | 40 000 000,00 | 40 180 440,00 | (180 440,00) | 100,45 | 20 692 707,00 | 206,2 |
| Жижиг эд хогшил худалдан авах зардал | 8 709 638,00 | 4 050 000,00 | 4 020 490,00 | 29 510,00 | 99,27 | (4 689 148,00) | 46,2 |
| Бусад зардал | 225 440,00 | | - | - | #DIV/0! | (225 440,00) | 0,0 |
| Зөөлөн эдлэл, нормын хувцас худалдан авах зардал | 398 700,00 | 3 500 000,00 | 3 409 000,00 | 91 000,00 | 97,40 | 3 010 300,00 | 855,0 |
| Төлбөр хураамж жижиг татварууд | 1 600 000,00 | 4 187 500,00 | 47 944 204,38 | (43 756 704,38) | 1144,94 | 46 344 204,38 | 2996,5 |
| Урсгал засварын зардал | 12 001 582,00 | 9 000 000,00 | 8 992 874,00 | 7 126,00 | 99,92 | (3 008 708,00) | 74,9 |
| Биеийн тамир уралдаан тэмцээн | 10 500 000,00 | 1 500 000,00 | 1 576 100,00 | (76 100,00) | 105,07 | (8 923 900,00) | 15,0 |
| Хог хаягдал устгал ариутгал | 24 215,83 | 8 640 000,00 | 8 670 650,00 | (30 650,00) | 100,35 | 8 646 434,17 | 35805,7 |
| Тэтгэвэрт гарахад нь олгох тэтгэмж | 18 724 308,00 | 30 935 200,00 | 16 775 364,00 | 14 159 836,00 | 54,23 | (1 948 944,00) | 89,6 |
| Төслийн зардал | 41 807 859,24 | | | | | (41 807 859,24) | 0,0 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| Нэг удаагийн тэтгэмж, | 622 400,00 | 4 900 000,00 | 28 281 424,00 | | | 27 659 024,00 | 4543,9 |
| VI. ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 589 857 128,90 | **801 956 300,0** | **813 741 258,6** | **(11 784 958,6)** | 101,5 | 223 884 129,72 | 138,0 |
| Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 95 222 828,89 | 30 000 000,0 | 69 782 333,00 | **(39 782 333,0)** | 232,6 | (25 440 495,89) | 73,3 |
| Төсвөөс санхүүжих | 494 634 300,00 | 771 956 300,0 | 743 958 925,62 | **27 997 374,4** | 96,4 | 249 324 625,62 | 150,4 |
| Мөнгөн хөрөнгийн оны эцийн үлдэгдэл | | | 8 875,95 | **(8 876,0)** | | 8 875,95 | |
| БАЙГУУЛЛАГЫН ТОО | 5 | 82,0 | 82,0 | **0,0** | | | |
| АЖИЛЛАГСАД БҮГД | 82 | 6,0 | 6,0 | **0,0** | | | |
| Удирдах ажилтан | 6 | 42,0 | 42,0 | **0,0** | | | |
| Гүйцэтгэх ажилтан | 42 | 34,0 | 34,0 | **0,0** | | | |
| Үйлчлэх ажилтан | 34 | | | | | | |

Төсвөөс 743,958.9 мянган төгрөгөөр санхүүжсэн, үндсэн ба туслах үйл ажиллагааны орлогоор 69,782.3 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ Гүйцэтгэлээр төсвөөс 27,997.4 мянган төгрөгийн санхүүжилт дутуу авч, өөрийн орлогын давалт 39,782.3 мянган төгрөг байна. Өөрийн орлогоосоо төсвийн санхүүжилтийн дутуу 11,784.9 мянган төгрөгийг санхүүжүүлсэн байна.

Тус байгууллагын үйл ажиллагаанд 855,443.2 мянган төгрөг зарцуулж төсвийг 53,486.9 мянган төгрөгийг хэтрүүлжээ. Энэ нь урьд оны үлдэгдэл 41,710.8 мянган төгрөгийг шилжүүлэн авч зарцуулсан, өөрийн орлого 11,784.9 мянган төгрөгөөр давсантай холбоотой байна.

Тэтгэмж, шагнал урамшуулал, буцалтгүй тусламжийн зардал 9,221.6 мянган төгрөгийг, 2012 оны төсвийн төлөвлөгөөнд ажиллагсдад олгох хоол унааны мөнгийг орхисон, цалингийн зардал хүрэлцэхгүй байсан тул зарим саруудад хоол унааны мөнгийг орлогын мөнгөнөөс олгож байсан.

Цалингийн төсөв, хоол унааны мөнгөний тооцоог БСШУЯ, Сангийн яаманд удаа дараа гарган өгсний үр дүнд төсөвийн тодотголоор хоол унааны мөнгө батлагдаж 2012 оны 7 сараас цалинтай хамт бодож олгожээ.

Номын сангийн уншигчийн карт,үнэмлэх хэвлүүлэх, ном сэлбэн засахын материал, канон принтерийн хор зэрэг номын сангийн үйлчилгээтэй холбоотой бичиг хэргийн зардал 1,002.3 мянган төгрөг хэтэрсэн байна.

Төсөвлөгдөөгүй жижиг зардалууд буюу төлбөр хураамж бусад зардал 1,491,8 мянган төгрөгөөр зэрэг нийт 65,587.5 мянган төгрөгийн зардал хэтэрч,бараа үйлчилгээний зардалаас 15,100.9 мянган төгрөг хэмнэж нийт дүнгээрээ 53,486.9 мянган төгрөгөөр хэтрүүлсэн харагдаж байгаач Сангийн сайдын 2007 оны 11 тоот тушаалаар батлагдсан "Төсвийн байгууллагын үйл ажиллагааны нэмэлт орлого болон зардлын хэмнэлтийг тооцох, зарцуулах, тайлагнах журам"-ын дагуу давсан орлогыг дараа жилд хууль журмын дагуу зарцуулах эрхийн дагуу зарцуулсан 41,675.1 мянган төгрөгийг хэтрэлтээс хасаж 11,811.8 мянган төгрөгөөр хэтрүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 2.2 "Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

## 10. Хуримтлагдсан ашиг

| Эхний үлдэгдэл | Бүртгэлийн бодлогын өөрчлөлт | Залруулсан үлдэгдэл | Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал | Ногдол ашиг | Төрийн болон ОНӨ-д ногдол ашиг | Төвлөрүүлсэн эсэх | Эцсийн үлдэгдэл | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| (200 629 652,65) | 5 833 722,90 | | (101 630 381,56) | | | | (296 426 311,31) | |

**11.БОЛЗОШГҮЙ АЛДАГДАЛ:** Өмнөх онуудын хуримтлагдсан алдагдал маш их хэмжээтэй байгаа нь санхүүгийн үзүүлэлтэнд муугаар нөлөөлөх магадлалтай.

| ***Аудитын тодруулга хийсэн:*** | ***Танилцаж зөвшөөрсөн:*** |
| --- | --- |
| Ерөнхий менежер.............. Ө.Ган-өлзий / | Аудитор .............................. Д.Дашхорлоо |
| Нягтлан бодогч ............../Ц.Сарантуяа / | Аудиторын туслах............................/ С.Хажид / |

9077847
УХА0450

"Б ЭНД С" АУДИТ ХХК-Д

**УЛААНБААТАР ХОТЫН ТӨВ НОМЫН САН**

14240 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Соёлын гудамж 7. Утас 7011-6700, Факс (976) 7011-5703
E-mail: mcl-ub@magicnet.mn, http://www.mcl.edu.mn

2012.10.09 № 49

танай ____________-ны № ____________-т

Зөвлөмжийн хариу

2012 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар "Орлогыг бодитой төлөвлөх" зөвлөмжтэй гарсан. Тус номын сан нь 2011 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар төрийн сан банкин дахь харилцах дансанд 41675800 төгрөгний үлдэгдэлтэй гарсан. Төсвийн төлөвлөгөөнөөс давсан энэхүү орлогыг Сангийн сайд, БСШУ-ны сайдын хамтарсан 2011.07.10-ны өдрийн 153/267 тоот тушаалаар батлагдсан "Соёл урлагийн байгууллагын үйл ажиллагааны нэмэлт орлогыг төвлөрүүлэх, зарцуулах журам"-ын дагуу зарцуулахаар хүсэлтээ Сангийн яаманд хүргүүлсэн боловч шийдвэр гаргахгүй байсаар 2012 оны 09 дүгээр сард Сангийн яам буцаан татан төвлөрүүлсэн. 2012 онд мөн орлогоо дансанд төвлөрүүлсэн бөгөөд зардлыг батлагдсан төсвийн дагуу хянуулан зарцуулж байна.

Номын сан нь Нийслэлийн Засаг Даргатай байгуулсан бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээний дагуу уншигч, ном олголт, ирц гэсэн 3 төлөвлөгөөт үзүүлэлтийг голчлон анхаарч ажилладаг бөгөөд уншлага үйлчилгээний хураамжийн үнэ тариф нь бусад номын сангуудаас хамгийн бага үнэтэй байгаа. Харин үйлчилгээний чанар хүртээмжээс шалтгаалж номын сангийн уншигч хэрэглэгч нь их байдаг. Номын сан ашгийн төлөө бус төрийн байгууллага тул үйлчилгээний чанар хүртээмжийг чухалчилдаг.

ЗАХИРАЛ Ө.ГАН-ӨЛЗИЙ

2140600024